

ТАНИЛЦУУЛГА

Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам батлах Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулсан тухай

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.10-д “Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Дээрх хууль тогтоомжид заасныг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, “Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-аар тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэлтэй холбоотой дараах харилцааг зохицуулахаар журамд тусгаж орууллаа. Үүнд:

- Нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцох
- Нэрийн дансны эхний үлдэгдэл
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл
- Нэрийн дансанд хүү тооцох
- Нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын бүртгэлийн
- Хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэх данс
- Нэрийн дансны жилийн эцсийн үлдэгдэл
- Нэрийн дансны орлогыг бүртгэх тусгай нөхцөлүүд гэх мэт болно.

---oOo---